



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
П.САЙНЗОРИГ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД**

Засгийн газрын XIII байр, Чингисийн өргөн чөлөө 11,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14251
Утас: (976-51) 26 31 79, Факс: (976-11) 31 23 15,
Цахим шуудан: info@mrt.gov.mn,
Цахим хуудас: www.mrt.gov.mn

2026.01.19 № 01/265
танай 2025.01.18 -ны № 52 -т

Мэдээлэл хүргүүлэх тухай

Агаарын навигацийн үйлчилгээний хураамжийн орлогын зарцуулалт, цаашид баримтлах зарчмын зохицуулалтын талаарх Таны асуулгыг судлан үзэж, дараах мэдээллийг хүргүүлж байна. Үүнд:

1. Улсын Их Хурлын 2024 оны 54 дүгээр тогтоолын дагуу нисэхийн аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын тогтолцоог сайжруулах, АНУ-ын Холбооны нисэхийн захиргаа (FAA)-аас хийх Олон улсын иргэний нисэхийн аюулгүй байдлын үнэлгээнд хамрагдах бэлтгэл ажлыг хангуулах зорилгоор 2025 онд Иргэний нисэхийн ерөнхий газрын санхүүжилтэд 26.0 тэрбум төгрөг баталсан. Энэ хүрээнд тус газраас дотоод зохион байгуулалт хийж, хяналтын байцаагчийн орон тоог 5-аар нэмэгдүүлэн 55 болгож, цалин, гадаад дотоод сургалт, хичээл үйлдвэрлэлийн дадлага, аудит баталгаажуулалт зэрэгт нийт 2,3 тэрбум төгрөгийн зардал гаргасан байна.

Мөн Иргэний нисэхийн 53 дүрмийг шинэчлэн баталж, АНУ-ын Холбооны нисэхийн захиргааны Олон улсын иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны үнэлгээнд хамрагдахтай холбогдуулан зөвлөх үйлчилгээний "Викс" компаниас гаргасан 175 үл нийцлийг олон улсын конвенц, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд залруулах ажлыг гүйцэтгэж байна.

2. Олон улсын иргэний нисэхийн байгууллагын "Нисэх буудал, агаарын навигацийн үйлчилгээний төлбөрийн бодлого" (Doc 9082) баримт бичигт конвенцын хэлэлцэн тохиролцогч улс бүр "агаарын навигацийн үйлчилгээний хураамжийг үйл ажиллагааны зардлыг нөхөх хэмжээнд зохистой тогтоож, нисэхийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд эргүүлэн зарцуулах" гэж заасан бөгөөд Монгол Улс 1998 оноос агаарын зайд нислэг үйлдэж буй агаарын хөлгөөс навигацийн үйлчилгээний хураамж тооцож эхэлсэн.

Агаарын навигацийн үйлчилгээний хураамжийн орлого нь өнгөрөлтийн нислэгийн тоотой шууд хамааралтай. Манай улсын агаарын зайгаар 2019 онд хоногт 400-500 орчим нислэг дамжин өнгөрдөг байсан бол цар тахал, ОХУ, Украины нөхцөл байдлаас үүдэн 2022 онд 70 орчим болж огцом буурсан бөгөөд өнөөдрийн байдлаар 230 орчим нислэг дамжин өнгөрч байна.

Иргэний нисэхийн ерөнхий газар нь 2021-2025 онд навигацийн үйлчилгээний хураамжаас нийт 975.8 тэрбум төгрөгийн орлого олж, улсын төсөвт 303.8 тэрбум төгрөг төвлөрүүлж, үйлдвэрлэлийн зардалд 873 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын

зардалд 48.6 тэрбум төгрөг зарцуулсан.

3.Агаарын тээврээр 2025 онд олон улсад 2,006,162 зорчигч тээвэрлэсэн нь 2024 оноос 15 хувь, цар тахлын өмнөх 2019 оноос 69 хувь өссөн үзүүлэлттэй байна. Манай улсын хувьд зорчигч урсгал бага хэдий ч агаарын тээврийн либералчлалын дүнд жилээс жилд тогтмол өсөлттэй байгаа тул зорчигчид суурилсан нисэхийн аюулгүй байдлын хураамж тогтоож, иргэний нисэхийн хяналт зохицуулалтын үйл ажиллагааны тодорхой хувийг санхүүжүүлэх боломжтой.

Энэхүү зохицуулалтыг Иргэний нисэхийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөлд тусгаж, бүрдүүлэхээр ажиллаж байна.

Түүнчлэн агаарын навигацийн үйлчилгээний хураамжийн орлогоос цаашид улсын төсөвт төвлөрүүлэхийг зогсоож, олон улсын гэрээ, конвенцын дагуу иргэний нисэхийн салбарт бүрэн зарцуулах замаар нисэхийн аюулгүй байдлын хяналтыг сайжруулах, салбарын санхүүжилтийн зохистой тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байгаа болно.

Хавсралт 2 хуудастай.



Зам, тээврийн яам
Сайд
Б.Дэлгэрсайхан
2026.01.19 16:55

Зам, тээврийн сайдын 2026 оны 01 дүгээр сарын
19-ний өдрийн 01/265 тоот албан бичгийн хавсралт

**Агаарын навигацийн үйлчилгээний хураамжийн сүүлийн 5 жилийн
орлого, зарцуулалт, хүрсэн үр дүнгийн тухай**

/тэрбум төгрөгөөр/

Он		2021	2022	2023	2024	2025	Нийт
Өнгөрөлтийн нислэгийн тоо		68,715	37,565	43,499	67,823	81,086	298,687
Навигацийн үйлчилгээний хураамжийн орлого		190,8	115,6	141,6	228,3	299,5	975,8
Улсын төсөвт	Төлөвлөгөө	150	150	150	80	80	61
	Гүйцэтгэл	122,9	16	5	80	80	303,8

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд 40 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр тусгасан.

Агаарын навигацийн үйлчилгээний хураамжаас сүүлийн 5 жилд 975,8 тэрбум төгрөгийн орлого олж, улсын төсөвт 303,8 тэрбум төгрөг төвлөрүүлж, үйлдвэрлэлийн зардалд 873,0 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 48,6 тэрбум төгрөг тус тус зарцуулж, дараах санхүүжилт хийсэн байна. Үүнд:

- Иргэний нисэхийн ерөнхий газар болон түүний харьяа агаарын навигацийн үйлчилгээний 4 алба, төв, орон нутгийн 21 нисэх буудал, шатахуун хангамж, газрын үйлчилгээ зэрэг нийт 2200 орчим ажилтантай үйлдвэрлэлийн албаны үйл ажиллагааны зардалд 2024 оныг дуустал жилд 160,9-213,6 тэрбум төгрөг;
- Агаарын навигацийн үйлчилгээнээс 2025 онд 299,5 тэрбум төгрөгийн орлого олж, "Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК нь 187,5 тэрбум төгрөгийн зардалтай ажилласан. Тус төв нь "Буянт-Ухаа" олон улсын нисэх буудал болон орон нутгийн 19 нисэх буудлын үйл ажиллагаа, агаарын навигацийн болон иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйл ажиллагааг санхүүжүүлсэн;
- Иргэний нисэхийн ерөнхий газар нь 2025 онд агаарын навигацийн үйлчилгээний орлогоос 80,0 тэрбум төгрөг улсын төсөвт төвлөрүүлж, 25,2 тэрбум төгрөгийн зардалтай ажилласан;
- Агаарын навигацийн үйлчилгээнд 2014-2025 онуудад 15 автомат хамааралтай ажиглалтын систем ADS-B болон 3 иж бүрэн газрын станц

суурилуулж нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээний найдвартай байдлыг сайжруулсан. Үүнээс 2022-2025 онд 6 ш ADS-B системд 11,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн;

- Аэродром, ойртолтын нислэгийн хөдөлгөөний удирдлагын дадлагажуурыг 3 тэрбум гаруй төгрөгийн хөрөнгө оруулалтаар шинэчилж, үйлдвэрлэлийн дадлага сургалтад ашиглаж байна;
- Үйлдвэрлэлийн найдвартай, хэвийн үйл ажиллагааг хангахад зориулж агаарын навигаци, нисэх буудал, газрын үйлчилгээ, нисэхийн аюулгүйн хамгаалалтын зэрэг үйлчилгээний ажилтнуудын сургалт, хичээл үйлдвэрлэлийн дадлагад жил бүр 2-3 тэрбум төгрөг төсөвлөн зарцуулж ирсэн;
- Засгийн газрын 2019 оны 150 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 352 дугаар тогтоолын дагуу “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих” төслийн 1,26 их наяд төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийн татварт Иргэний нисэхийн ерөнхий газар 2019-2025 онд нийт 43,8 тэрбум төгрөг Төв аймгийн төсөвт төвлөрүүлсэн;
- Засгийн газрын 2023 оны 201 дүгээр тогтоолын дагуу орон нутгийн нислэгийг сэргээн тогтворжуулахад зориулж “МИАТ” ТӨХК-д 8,6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон;
- Мөн орон нутгийн зарим нисэх буудлуудын аэродромыг сайжруулах чиглэлээр хөөрч буух зурвас, явгалах зам, агаарын хөлгийн зогсоолын хүчитгэлийн их засварыг хийж, техникийн шаардлагад нийцүүлэн хүлээн авсан. Тухайлбал, Өмнөговь аймгийн нисэх буудлын аэродромын засварын ажлыг 2025 онд 12,4 тэрбум төгрөгөөр санхүүжүүлж, хэрэгжүүлсэн зэрэг болно.

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ